



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

**Багахангай дүүргийн Соёлын ордны
эргэлтийн бус хөрөнгийг данснаас
хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,580,900.0 /нэг сая таван зуун наян мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багахангай дүүргийн Соёлын ордон /Б.Алтанцоож/-д зөвшөөрсүгэй.

2. Хавсралтад дурдсан 5 нэр төрлийн 1,580,900.0 /нэг сая таван зуун наян мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Багахангай дүүргийн Соёлын ордон /Б.Алтанцоож/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 03... дугаар сарын 19... өдрийн 1/8... тоот тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай дүүргийн Соёлын ордон

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	ЭБХХХ комиссын хурлын шийдвэр
1	Микрофон BE-23	12	ш	1	120,000.00	120,000.00	120,000.00	0	эвдэрсэн	Актлах	0	Татах
2	Дижитал камер Panasonic	10	ш	1	679,400.00	679,400.00	679,400.00	0	эвдэрсэн	Актлах	0	Татах
3	Зайны микрофон	6	ш	1	351,500.00	351,500.00	351,500.00	0	эвдэрсэн	Актлах	0	Татах
	Тоног төхөөрөмжийн дүн					1,150,900.00	1,150,900.00					
4	Оффис ширээ	12	ш	1	320,000.00	320,000.00	320,000.00	0	эвдэрсэн	Актлах	0	Татах
5	Ширээ /компьютерийн/	12	ш	1	110,000.00	110,000.00	110,000.00	0	эвдэрсэн	Актлах	0	Татах
	Тавилга эд хогшлын дүн					430,000.00	430,000.00	0				
	Нийт данснаас хасагдах хөрөнгийн дүн					1,580,900.00	1,580,900.00	0.00				
	Үүнээс: Худалдах хөрөнгийн дүн											
	Устгах хөрөнгийн дүн						-					
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн						1,580,900.0					
	Худалдсанаас олох орлого											
	НӨАУГ-т төвлөрүүлэх 30%											